



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/512

Булган сум

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалтын ажил
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, 9.6, 9.7, 9.8 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2, 28.4 дэх хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/207 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг аймгийн хэмжээнд 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрөөс 08 дугаар сарын 24-нийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Дархлаажуулалтад шаардагдах вакцин, био бэлдмэлийг татан авч сумдад хуваарилах, сумын мал эмнэлэг, малын эмч нарыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн)-т, орон нутагт зохион байгуулан удирдлага, хүн хүч, машин техник, бусад шаардлагатай зүйлээр хангаж ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
07 дугаар сарын 25-ны/ний өдрийн
А.Б.12 дугаар захирамжийн хавсралт



БОГ МАЛЫН МЯЛЗАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Сумын нэр	Дархлаажуулах малын тоо					Шаардлагатай вакцин	
		Хурга	Ишиг	Нийт хурга	Нийт ишиг	Нийт бог мал	Шингэлэгч / мл /	Вакцин
1	2	3	4	5	6	7	8	9
1	Баян-Агт	57,800	41,400	57,800	41,400	99,200	99,200	99,200
2	Бгяннуур	14,400	18,500	14,400	18,500	32,900	32,900	32,900
3	Бугат	18,500	12,100	18,500	12,100	30,600	30,600	30,600
4	Булган	13,700	9,300	13,700	9,300	23,000	23,000	23,000
5	Бүрэгхангай	64,100	40,600	64,100	40,600	104,700	104,700	104,700
6	Гурванбулаг	69,500	49,800	69,500	49,800	119,300	119,300	119,300
7	Дашинчилэн	41,700	35,800	41,700	35,800	77,500	77,500	77,500
8	Могод	93,200	35,200	93,200	35,200	128,400	128,400	128,400
9	Орхон	63,500	48,700	63,500	48,700	109,200	109,200	109,200
10	Рашаант	41,700	26,600	41,700	26,600	68,300	68,300	68,300
11	Сайхан	55,700	24,300	55,700	24,300	80,000	80,000	80,000
12	Сэлэнгэ	20,300	11,900	20,300	11,900	32,200	32,200	32,200
13	Тэшиг	14,500	11,000	14,500	11,000	25,500	25,500	25,500
14	Хангал	13,000	12,300	13,000	12,300	25,300	25,300	25,300
15	Хишиг-Өндөр	55,400	33,100	55,400	33,100	88,500	88,500	88,500
16	Хутаг-Өндөр	53,300	28,700	53,300	28,700	82,000	82,000	82,000
	Нийт	690,300	436,300	690,300	436,300	1,126,600	1,126,600	1,126,600